



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 02 дөр

Дугаар 35

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт шаардлагатай нийт 11,690,000 /арван нэгэн сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг бэлтгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) -д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

480219076

20

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын
02 өдрийн 35 тогтоолын 1 хавсралт



Байгаль орчин аялал жуулчлалын газрын
худалдан авах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Компьютер /суурин/	2	1,740,000	3,480,000
2	Компьютер /зөөврийн/	1	1,650,000	1,650,000
3	Принтер /олон үйлдэлт/	2	455,900	911,800
4	Компьютерийн ширээ	1	450,000	450,000
5	Бичгийн ширээ	2	380,000	760,000
6	Сандал /эргэдэг/	8	285,000	2,280,000
7	Камерны хөл	1	358,200	358,200
8	Өнгөт принтер	1	1,800,000	1,800,000
	Нийт дүн			11,690,000 /арван нэгэн сая зургаан зуун ерэн мянга/